



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/158

Булган

┌ Зөвлөгөөн зохион байгуулах тухай ┐


Монгол улсын Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.4, Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 1.4.4, 1.4.5, Засгийн газрын 2018 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.5, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Малын эмч нарын зөвлөгөөнийг 2019 оны 03 сарын 09-нөөс 2019 оны 03 сарын 10-ны өдрүүдэд Булган суманд зохион байгуулсугай.

2. Малын эмч нарын зөвлөгөөнийг зохион байгуулахад шаардагдах зардал 605000 /зургаан зуун таван мянга/ төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Батцогт/-т зөвшөөрсүгэй.

3. Малын эрүүл мэндийн талаар баримтлах аймгийн бодлого, чиглэлийн талаар зохих мэдээллийг хүргэж, Зөвлөгөөнийг чанарын өндөр түвшинд, үр дүнтэй зохион байгуулахыг Мал эмнэлгийн газар /Л.Галбадрах/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

2019-133

Аймгийн Засаг даргын 2019 оны 03 сарын 02  
өдрийн 158 тоот захирамжийн хавсралт

АЙМГИЙН МАЛЫН ЭМЧ НАРЫН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Анонс	ш	1	95 000	95 000
2	Гарын авлага	ш	100	2500	250 000
3	Сургалтын байрны зардал	ш	1	150 000	150 000
4	Сонин	ш	600	100	60 000
5	Бичгийн цаас	ш	5	10 000	50 000
	Нийт				<b>605 000</b>